

**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
“ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ДҮҮРГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙН
2017-2020 ОНЫ БИЕЛЭЛТ ГАРГАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Багануур дүүрэг

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтүүд	Шалгуур үзүүлэлтүүд		Биелэлтийн хувь
			2017-2020 он	Биелэлт	
Зорилт-1. Хөдөлмөрийн аюулгүй, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, сургалт сурталчилгааг зохион байгуулах, зөвлөмж зөвлөгөө өгөх					
1.1 ХАБЭА-н тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг, түүнд зарцуулах хөрөнгийг төлөвлөх					
1.	1.1.1 /Хөдөлмөрийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/114-р тушаал/ “Зөвлөл байгуулах, орон тооны ажилттан ажиллуулах норматив батлах тухай”-д заасны дагуу ХАБЭА-н зөвлөл, орон тооны ажилтнуудыг ажиллуулах, тэдгээрийн мэдээллийг санг бүрдүүлэх	ХАБЭА-н салбар зөвлөл, орон тооны ажилтнуудын мэдээллийн сантай болсон байна.	Паркийн удирдлага 2019 оны байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны орон тоог нэмж батлуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч даргад уламжилсан. Нийслэлээс 2019 онд нэмж орон тоо батлуулах боломжгүй, 2020 оноос паркуудын бүтэц орон тоог шинэчилнэ гэсэн хариуг өгсөн боловч шинэчлэгдээгүй. 2019 оны 1 сард паркийн мэргэжилтэн Ш.Ууганбаярыг ХНУША-ийн ХАБЭА ажилтан бэлтгэх 1 сарын сургалтад хамруулсан. 2019 оны 11 дүгээр сард дүүргийн ЗДТГ, ХХҮХ хамтарсан сургалтад паркийн мэргэжилтэн Э.Энхзаяа, Б.Мөнгөнхуяг нар хамрагдаж сертификат авсан.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны орон тоог Нийслэлээс нэмж батлах боломжгүй.	-
	1.1.2 Эрүүл аюулгүй ажлын байрыг дэмжих чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, шийдвэр гаргах үйл ажиллагаандаа хамт олны төлөөлөгчдийг оролцуулах ажлыг ажил олгогч байгууллагад нэвтрүүлэхэд хамтран ажиллах	Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд тусгасан байна.	2018,2019 онуудад Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэн ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан “Эрүүл ажлын байр удирдамж”-ийн хэрэгжилтийн хүрээнд 7 чиглэлээр сургалт зохион байгуулсан. 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Спорт, эрүүл мэндийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн “Сүрьеэгүй дүүрэг дэд хөтөлбөр”, цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл, мэдээ, тайлангуудыг хугацаанд нь гарган үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.	Байгууллагын дотоод журмын 6.2.3, Хөдөлмөрийн дотоод журмын 3.9 дэх заалтад тусгагдсан.	100%

<p>1.1.3 Онцгой байдлын үед/гал түймэр, зуд, осол, голомтод гарсан халдварт өвчин/ авран хамгаалах, анхны тусламжийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх, ажиллагсдыг сургаж бэлтгэх талаар сургалт зохион байгуулж, хамтран ажиллах</p>	<p>Онцгой байдлын үед /гал түймэр, зуд, осол, голомтод гарсан халдварт өвчин/ авран хамгаалах, анхны тусламжийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөтэй болж, ажиллагсдыг сургалтад хамруулсан байна.</p>	<p>2018 онд Багануур дүүргийн Онцгой байдлын газраас дүүргийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан “Гамшиг ослын үед /гал түймэр, зуд, осол/ авран хамгаалах анхны тусламжийн бэлэн байдлын талаар мэдлэг олгох сургалтад хамрагдсан. 2019 онд Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб байгуулан бүтэц бүрэлдэхүүнийг томилсон. Багануур дүүргийн онцгой байдлын хэлтсээс Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулсан. 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгууллагын гамшгаас хамгаалах штабын бүрэлдэхүүнийг томилж, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан. Багануур дүүргийн Гамшгаас хамгаалах бэлэн байдлын нэгдсэн үзлэгт 10 дугаар сарын 29-ний өдөр штабын бүрэлдэхүүн амжилттай оролцсон. 11 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд Нийслэлээс зохион байгуулагдах байсан үзлэг ЗГ-ын 2020 оны “Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоолыг үндэслэн тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна.</p>	<p>Байгууллагын гамшгаас хамгаалах штабын бүрэлдэхүүнийг томилж, хувцас хэрэглэлээр ханган, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус сургалт болон үзлэгт амжилттай хамрагдсан.</p>	<p>100%</p>
<p>1.2 Ажлын байран дээр хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих</p>				
<p>1.2.1 Аж ахуйн нэгж байгууллагуудын нийтлэг мөрдөж буй дүрэм, журам, сануулсан тэмдэг тэмдэглэгээ, анхааруулга, сэрэмжлүүлгийг хялбар, ойлгомжтой болгон түгээх хяналт тавих</p>	<p>Аж ахуйн нэгж байгууллагын нийтлэг мөрдөж буй дүрэм, журам, сануулсан тэмдэг тэмдэглэгээ, анхааруулга, сэрэмжлүүлгийг хялбар ойлгомжтой болгон түгээсэн байна.</p>	<p>Байгууллагын албан хаагчдад Галын аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулсан. Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХХК буюу түрээслэгч байгууллагаас анхааруулах санамж зөвлөмжийг ажлын өрөөнд байршуулж, аврах гарцын схемийг танилцуулсан. Байгууллагын болон архивын өрөөнд галын буланг норм стандартын дагуу бүрдүүлсэн. МУ-ын ЗГ-ын 2017 оны 67 дугаар тогтоолоор, жил бүрийн гуравдугаар сарын гурав дахь 7 хоногт “Газар хөдлөхийн аюулыг таниулах, урьдчилсан сэргийлэх өдөр”-ийг тэмдэглэхээр шийдвэрлэсний дагуу 2019.03.21-ний 16:03 цагт гамшигийн аюулын дохио дуугарч байгууллагын 10 ажилтан бэлэн байдлыг хангах, аврах ажиллагааны сургуулилтад хамрагдсан. Ковид-19 цар тахалын хүрээнд мэргэжлийн байгууллагаас өгч буй зөвлөмжийг мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Мөн</p>	<p>Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан.</p>	<p>100%</p>

			холбогдох сургалтыг мэргэжлийн байгууллагаас болон дотооддоо зохион байгуулж ажилласан.		
1.3 ХАБЭА-н мэргэшүүлэх сургалтанд аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан, мэргэжилтнүүдийг хамруулах талаар төрийн болон ТББ, ААН-тэй хамтран ажиллах					
1.3.1	Аж ахуйн нэгж байгууллага, орон нутагт ХАБЭА-н тухай хууль, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг ХАБЭА-н мэргэжилтнүүдэд зохион байгуулах ажлыг ажил олгогч эздийн холбоо, үйлдвэрчний эвлэл болон мэргэшсэн сургалтын байгууллага, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах	Аж ахуйн нэгж байгууллагын ХАБЭА-н мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулагдсан байна.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс санаачлан дүүргийн салбар зөвлөл болон Монголын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшсэн холбоотой хамтран зохион байгуулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудыг чадавхжуулах” сэдэвт сургалтад холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан. Монголын мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбооны гүйцэтгэх захирал С.Даваанямын “Аюулгүй байдал байгууллагын соёл” сэдэвт сургалтад хамрагдсан.	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан.	100%
1.3.3	Ажилчдад ХАБЭА-н хууль тогтоомжийг сурталчлах эрсдэлт зан үйлийг өөрчлөх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зэрэг ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулах	ААНБ-дад эрсдэлт зан үйлийг өөрчлөх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зэрэг ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулсан байна.	“Аюулгүй байдал байгууллагын соёл” сэдэвт сургалтад хамрагдсан мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнэ ХАБЭА тухай хууль эрх зүй болон үйлдвэрийн байгууллага, оффисын байгууллагад мөрдөгдөх аюулгүй ажиллагаа, Монголын мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбооны тухай мэдээлэл хийсэн. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудыг чадавхжуулах” сургалтад хамрагдсан инженер Б.Мөнгөнхуяг байгууллагын албан хаагч нарт сургалтын мэдээлэл, олон улсын стандарт, үйлдвэрийн осол гэмтлийн талаар мэдээлэл хийсэн.	Сургалтуудыг зохион байгуулж ажилласан.	100%
Зорилт-2. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг судлан бүртгэх, мэдээллийн санд оруулах, эрүүл мэндийн болон хөдөлмөрлөх чадварыг сэргээн засах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх					
2.1 Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт тогтмол хамруулах ажлыг хэвшүүлж мөрдүүлэх					
2.	2.1.1 Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340-р тушаалын дагуу ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт тогтмол хамруулах, хугацаат үзлэгийн мөрөөр арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамрагдсан ААНБ, ажиллагсдын тоо нэмэгдсэн байна.	2018 онд В, С вирус илрүүлэх урьдчилсан шинжилгээнд байгууллагын 25-35 насны 6 албан хаагч хамрагдсан. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 10 ажилтан хамрагдсан ба 1 ажилтан нь чихрийн шижин өвчинтэй оношлогдсон. Уг ажилтан хоолны дэглэм сахиж байна. Багануур дүүргийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/122 дугаар захирамжийн дагуу “Хүн амын	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан.	100%

		<p>бие бялдын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох” сургалт арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Байгууллагын нийт албан хаагчдын дунд бие бялдын түвшин тогтоох сорил, түүний ач холбогдол, дасгал хөдөлгөөний талаар мэдээлэл өгч сорил авах ажлыг зохион байгуулж нийт 9 хүнээс авсан. Мөн албан хаагчдыг дасгал хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх үүднээс ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол хийлгэж байна.</p> <p>2020.01.23-ны өдөр дүүргийн хэмжээнд зохион байгуулагдсан Тэмбүүг устгая аяны нээлтийн үйл ажиллагаанд хамт олноороо оролцсон. Уг аяны хүрээнд БЗДХӨ, Тэмбүү өвчний өнөөгийн байдал, урьчилан сэргийлэх арга замууд сэдвээр ДОХ БЗДХӨ кабинетийн их эмч Л. Мөнхбаяр сургалт орж, байгууллага албан хаагчдын урьдчилан сэргийлэх үзлэгийн хуваарийг тараан, ЭМТ-өөс арга хэмжээнд оролцсон ажилтан, албан хаагч, иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн.</p>		
<p>2.1.4. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих цогц бодлогын хүрээнд төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх /- Ахуйн байр, хооллох өрөө нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт, ариун цэврийн шаардлагад нийцсэн байх, стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн өрөөтэй байх, -Стандартын шаардлага хангасан хүрэлцээтэй халуун, хүйтэн усаар хангагдсан байх, ариутгал халдваргүйтэл тогтмол хийлгэдэг болох, -Ажиллагсдад сүү, цагаан идээ, төрөл бүрийн ногоо жимс бүхий чанар сайтай “Эрүүл” хоол хүнсээр хөнгөлөлттэй үйлчилдэг, хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг хор саармагжуулах</p>	<p>Цогц бодлогын хүрээнд төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>2018 онд Ажлын байрны халаалтын системийг сольж тав тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн. Ажилчдын цайны цагаар ашиглах гал тогооны буланг бий болгож тохижуулсан.</p> <p>2019 онд Байгууллагын оффисын өрөө нь техникийн зориулалттай өндөр тааз, цонхтой өрөө байсан тул албан хаагчдыг стандартын ажлын байраар хангах үүднээс засварлаж, өрөөний цонхонд зориулалтын хөшгийг шинээр тогтоосон.</p> <p>Түрээслүүлэгч байгууллагаас ариун цэврийн өрөөний суултуур болон угаалтуурын холигчийг иж бүрэн сольж өгсөн.</p> <p>Оффисын агааржуулалтын нөхцөлийг сайжруулахын тулд албан хаагч бүр хувийн зардлаар ширээний жижиг сэнс тавьж төсөв хэмнэн ажиллаж байна.</p> <p>Жавелины уусмалыг норм дүрмийн дагуу ашиглах талаар ЭМТ-ийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн ажилтнаас зөвлөгөө авч хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2020 онд Хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан ажилтан албан хаагчдыг томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор халуун аарц аян өрнүүлсэн.</p>	<p>Төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан.</p>	<p>100%</p>

	бодис, хүнсний бүтээгдэхүүн, хоолоор хангадаг байх гэх мэт/		Корона вирусын цар тахалтай хөлбоотойгоор албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, ажлын байранд чийгтэй цэвэрлэгээг хийж, хаалганы бариулыг 2 цаг тутамд спиртээр тогтмол ариутгаж байна. Мөн ажилчдыг Паркийн нэгж болох Монхимо ХХК-ийн бүтээгдэхүүн /санитол/ гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр ханган ажиллаж байна.		
Зорилт-4. Эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох чиглэлээр ажлын байранд нөлөөлж сөргөөр нөлөөлж буй химийн болон бусад хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах түүнээс урьдчилан сэргийлэх, ажиллагсадыг эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцлөөр хангах					
4.1 ААНБ-ууд ажлын байр бүрт эрсдлийн үнэлгээг хийж, эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэвшүүлэх					
4.	4.1.1 ААНБ-ыг галын аюулаас урьдчилан сэргийлэх анхан шатны багаж хэрэгслийг MNS:5566-2005 стандартын дагуу байрлуулах талаар хамтран ажиллах	MNS:5566-2005 стандартын шаардлага хангагдсан байна.	MNS:5566-2005 стандартын дагуу галын аюулаас урьдчилсан сэргийлэх анхан шатны багаж хэрэгслийг стандартын дагуу байрлуулсан.	Шалгуур үзүүлэлт бүрэн хангагдсан.	100%
	Иргэдэд эрүүл, аюулгүй ажиллаж амьдрах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгох, соён гэгээрүүлэх ажлыг хийж сурталчлах 4.1.4 Дасгал хөдөлгөөнөөр хичээллэх боломжоор хангагдсан чийрэгжүүлэлтийн өрөө танхимтай байх	Чийрэгжүүлэлтийн өрөө танхимтай болсон байна. Чийрэгжүүлэлтийн танхимтай байгууллагууд сайжруулсан байна.	Албан хаагчдыг дасгал хөдөлгөөн хийлгэх, чийрэгжүүлэх зорилгоор сард 3 удаа түрээслэгч байгууллагын чийрэгжүүлэх зааланд ширээний теннис тоглож байна.	Шалгуур үзүүлэлт бүрэн хангагдсан.	100%



ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
КЛАСТЕР ИНЖЕНЕР

Э.ЭНХЗАЯА